



МОНГОЛ УЛС

Төрийн тэргүүн: Цахиагийн Элбэгдорж
Засгийн газрын тэргүүн: Чимэдийн Сайханбилэг

Цагдан саатуулах газарт эрүүдэн шүүх болон зүй бус харьцаа өргөн тархсан. Хотод албадан нүүлгэсээр байна. Хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, жендэрт суурилсан алагчлалыг огт тоохгүй хэвээр байна. "Non-refoulement" зарчмыг зөрчин орогнол эрэгчдийг хүний эрхийн ноцтой зөрчилд өртөх эрсдэлтэй улсад албадан буцаажээ.

Үндсэн мэдээлэл

Монгол улс 10-р сард Хүчээр алга болгохоос бүх хүмүүсийг хамгаалах тухай олон улсын конвенцийг соёрхон батлав. Гэвч 2012 онд соёрхон баталсан ИУТЭОУП-ын цаазаар авах ялыг халах тухай 2-р Нэмэлт Протоколын дагуу үндэсний хууль тогтоомждоо өөрчлөлт оруулаагүй байна.

Эрүүдэн шүүх болон зүй бус харьцаа

Эрүү шүүлт болон зүй бус харьцааг ялангуяа "хэрэг хүлээлгэх"-ийн тулд хэрэглэх нь хүний эрхийн ноцтой асуудал хэвээр байна. Хорих, цагдан хориход баривчлагдсан хүмүүсийг эрүүдэн шүүж, зүй бус харьцсан хэрэгт сэжиглэгдсэн цагдаа, хорихын хянагч нарыг үр дүнтэй мөрдөн шалгаагүй ба хариуцлага тооцоогүй байна.

Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн Байцаах Алба 1-р сард татан буугдсан. Уг Мөрдөн Байцаах Алба нь байцаалтын явцад хүчээр мэдүүлэг авсан гэх цагдаа, прокурор, шүүгчийн эсрэг гомдлыг мөрдөн шалгах үүрэгтэй байсан. Гэтэл Монгол улсад эрүүдэн шүүх болон зүй бус харьцсан хэргүүдийг цагдаагийн байгууллага шалгах болсон нь ийм төрлийн хэргийг үр дүнтэй мөрдөн шалгах хараат бус механизм дутагдаж байгааг харууллаа.

2-р сард Архангай аймгийн цагдан хорих төвд хоригдож байхад нь хэрэг хүлээлгэхийн тулд цахилгаан бороохойгоор цохиулж, зодсон хэмээн гурван иргэн

Монголын Хүний Эрхийн Үндэсний Комисст гомдол гаргажээ. Тэдний нэг нь хэрэг хүлээлгэхийн тулд хүч хэрэглэж, 6 хоног хоолгүй хорьсон хэмээн мэдүүлжээ. УЕПДМБА нь татан буугдсан тул Архангай аймгийн цагдаагийн хэлтэс энэ хэргийг мөрдөн шалгасан. Улмаар эрүүдэн шүүж, хэрцгий, хүнлэг бусаар харьцсан талаарх гомдлыг хэрэгсэхгүй болгожээ.

Орон байртай байх эрх - Албадан нүүлгэлт

Улаанбаатар хотын гэр хорооллын иргэд шаардлага хангасан орон байр, цэвэр ус, эрүүл ахуйн нөхцөл зэрэг үндсэн үйлчилгээгээр хангагдаж чадахгүй байна. Улаанбаатар хотын 7-р бичил хорооллын зарим иргэдтэй зөвлөлдөж, эсхүл хууль зүйн хамгаалалт, баталгаа өгөлгүйгээр 2007 онд орон гэрээс нь албадан нүүлгэсэн ч, амласан орон сууцаа олгоогүй байна.

Ялгаварлан гадуурхалт

Үндэс угсаа, жендэр, бэлгийн чиг баримжаа болон хөгжлийн бэрхшээлд суурилсан ялгаварлан гадуурхалт байсаар байна. Үндэсний цөөнх болон хөдөө, орон нутагт амьдардаг ядуу, нийгмээс гадуурхагдсан эмэгтэйчүүдийг алагчлан үзэх жендэрийн ялгаварлал байна. Лесбиян, гей, бисексуал, трансжендэр болон интерсекс хүмүүсийн эсрэг халдлага, дайралт, ялгаварлан гадуурхалт байсаар байна. Хуулиндаа бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт эрэгтэй хүн болон хөвгүүнийг хохирогч гэж тодорхойлоогүйгээс эрэгтэй хохирогчдод шаардлагатай эмчилгээ сувилгаа, нөхөн олговор авах, шүүхэд хандах, гомдлоо барагдуулахад нь бэрхшээл тулгарч байна.

Дүрвэгсэд ба орогнол эрэгчид

2014 оны 5-р сард Өвөр Монголын Өөртөө Засах Орны хоёр орогнол эрэгчийг БНХАУ-руу албадан буцаажээ. Тухайн үед НҮБ-ын Дүрвэгсэдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын газраас тэдний нэгэнд дүрвэгчийн статус өгөхөөр шалгаж байсан ч статус тодорхойлох процесс дуусаагүй байхад "non-refoulement" зарчмыг зөрчин албадан гаргаж, хүний эрхийн ноцтой зөрчилд өртөх эрсдэлтэй улсад шилжүүлэн өгчээ.

Эмнести Интернэшнл нь хүний эрхийн зөрчлийг төгсгөл болгохын төлөө кампанит ажил өрнүүлдэг 150 гаруй орны 7 сая гаруй гишүүд, дэмжигчид, хүний эрхийн хамгаалагчдыг эгнээндээ нэгтгэсэн дэлхийн хөдөлгөөн юм.

Бидний хүсэл Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт адил тэгш эдлүүлэхэд оршино.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид байж, ихэнхдээ гишүүд, олон нийтийн хандиваар санхүүждэг

Монголын Эмнести Интернэшнл
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу-44
Утас/Факс: 976-11-324705

aimncc@magicnet.mn
www.amnesty.mn